



Хууль зүй, дотоод
хэргийн яам



НҮБ-ын Хүүхдийн Сан

ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮҮХДИЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ХОРОО

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТОЙМ



Улаанбаатар хот
2009 он

DDC
364.36
Г-923

Энэхүү тайланг хөндлөнгийн үнэлгээний зөвлөх баг Жейн С Ким,
Р.Оюунбилэг нар боловсруулсан болно.

Тайлангийн агуулга нь НҮБ-ын Хүүхдийн Сангийн байр суурийг
илэрхийлээгүй болно.

@ НҮБ-ын Хүүхдийн Сан
2009 он

НҮБ-ын 2-р байр
Нэгдсэн Үндэстний гудамж 12, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976 (11) 312185
Факс: 976 (11) 327383
Цахим шуудан: ulaanbaatar@unicef.org
Цахим хуудас: www.unicef.org/mongolia

ISBN 978-9929-64-22-7

ГАРЧИГ

1	ТАНИЛЦУУЛГА	4-5
1.1	Зорилго	
1.1	Хамрах хүрээ	
2	“ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮҮХДИЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ХОРОО”-НЫ ҮНЭЛГЭЭ.....	5-20
2.1	Танилцуулга: Эрх зүйн орчин, хорооны хөгжлийн түүхэн товчоо	
2.1	Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны чиг үүрэг, бүтэц	
2.1	Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны ажиллагаа: үр дүн, үр дагавар, дутуу орон зай, сургамж	
3	ЗӨВЛӨМЖ	21-33
3.1	Нийтлэг зөвлөмж	
3.2	Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороог үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх	
3.3	Манлайлах ба эзэн байх	
3.4	Судалгаа, баримт нотолгоо	
3.5	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн зөвлөмжүүд	
3.6	Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны үзэл баримтлалын өөрчлөлт	
3.7	Хүүхдийн хууль эрх зүй	

I. ТАНИЛЦУУЛГА

Монголын хүүхэд, өсвөр үеийнхэн нь улс оронд үргэлжлэн буй улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийн улмаас бий болсон хүндрэл бэрхшээлийг даван туулах шаардлагатай тулгарч буй “шилжилтийн үеийнхэн” юм. Хүүхэд, залуус хууль зөрчсөн үйлдэлд өртөх өндөр эрсдэл бүхий цаг үед амьдарч байна. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн тоо сүүлийн жилүүдэд хурдацтай өсч, 1991 онд 733 байсан бол 2008 онд 1,080 болжээ. Эдгээр гэмт хэргийн ихэнх нь хулгайн гэмт хэрэг байдаг. Хүүхэд, залуусын энэ үйлдэлд төрөөс хариу арга хэмжээг хэрхэн авах нь тэднийг цаашдаа хуулийг хүндэтгэсэн иргэн болох уу, гэмт хэргийн ертөнцөд амьдрах уу гэдгийг шийдэхэд чухал нөлөөтэй. Харамсалтай нь, анх удаа эсвэл хөнгөн гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд хатуу шийтгэл оноох, улмаар байцаан шийтгэх ажиллагааны янз бүрийн шатанд эрх чөлөөг нь хязгаарлаж байна.

НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр “Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороо” (ГХХХАЭХ) төслийг нийслэлийн Баянгол, Багануур дүүрэг болон Хэнтий аймагт 2006 оны 9 сараас эхлэн туршин хэрэгжүүлээ. Төрийн болон хууль хяналтын байгууллагын албан хаагчид, орон нутгийн иргэд, улмаар хүүхэд, гэр бүлийн гишүүд энэхүү төслийн чухал хэрэгцээтэй болохыг тэмдэглэн, талархаж байна. Төслийн үйл ажиллагааг бусад нутгуудад түгээн дэлгэрүүлэх боломжийн талаар хэлэлцэж байна. Мөн эрүүгийн, захиргааны, хөдөлмөрийн, хүүхдийн эрхийг хамгаалах тухай болон насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэхтэй холбогдолтой бусад хуулиудад өөрчлөлт оруулах оролдлогууд хийгдэж байна.

1.1 Зорилго

Хуулийн өөрчлөлтийг санаачлах, туршилтын загварыг түгээн дэлгэрүүлэхийн өмнө, хэрэгжиж буй төслийн хэрэгцээ шаардлага, үр дүн, нөлөөг үнэлж, дүгнэх нь чухал байлаа. 2009 оны 3-р сард хөндлөнгийн үнэлгээний баг төслийн үнэлгээний ажлыг эхэлж, Улаанбаатар хотын Баянгол, Багануур дүүрэг, Хэнтий аймагт ажилласан болно. Ингэхдээ хүүхэд, тэдний гэр бүл, орон нутгийн удирдлага, нийгмийн ажилтан, халамжийн байгууллагын мэргэжилтнүүд, насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх хорооны нарийн бичгийн дарга нар, НҮБ-ын Хүүхдийн Сангийн удирдлага болон мэргэжилтнүүд, хууль хяналтын байгууллагынхан буюу шүүгч, прокурор, цагдаа, өмгөөлөгч, холбогдох бусад яамдын мэргэжилтнүүд зэрэг 100 гаруй хүмүүстэй уулзаж ярилцсан.

Энэхүү хураангуй тайланд үнэлгээний гол дүгнэлтүүд, төсөл хэрэгжүүлэх явцад хуримтлагдсан туршлага, сургамж зэрэг төслийг бусад орон нутагт

түгээн дэлгэрүүлэхэд шаардлагатай мэдээллүүд болон хүүхдэд ээлтэй эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх талаар НҮБ-ын Хүүхдийн Сан болон Монгол Улсын Засгийн Газарт зориулсан санал зөвлөмжийг боловсруулсан.

1.2 Хамрах хүрээ

Оролцооны болон бусад аргыг хослуулан хийсэн энэхүү үнэлгээ нь дараахь асуултуудад хариулт өгөхийг зорилоо. Үүнд:

1. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн стратеги болон үйл ажиллагаанууд нь тавьсан зорилго, зорилтоо хэр хэмжээнд хэрэгжүүлсэн бэ?
2. Төслийн эерэг болон сөрөг үр нөлөө/үр дүн юу байсан бэ? Урьдчилан тооцоолоогүй үр нөлөө/үр дүн гарсан уу?
3. НҮБ-ын Хүүхдийн Сан болон оролцогч талуудад ямар бэрхшээл, сорилт тулгарсан бэ? Хэрхэн шийдсэн бэ? Ямар боломжуудыг ашигласан бэ?
4. НҮБ-ын Хүүхдийн Сан болон хамтрагч талууд ямар сайн туршлага, сургамж олж авсан бэ?
5. Төслийг цаашид хэрэгжүүлэхэд ямар зөвлөмж өгөх вэ?
6. Энэхүү төслийг өөр орон нутагт хуулбарлан хэрэгжүүлэх буюу хүрээг нь өргөтгөх, тухайлбал, хууль эрх зүйн болон бодлогын шинэчлэл хийх сурталчилгааны ажилтай уялдуулах зэргээр өргөжүүлэх тал дээр та ямар санал хэлэх вэ?

2. "ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮҮХДИЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ХОРОО" ҮНЭЛГЭЭ

2.1 Танилцуулга

Эрх зүйн орчин: Өнгөрсөн арван жилийн хугацаанд Монгол орон хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх талаар их зүйл хийжээ. Монгол улс Хүүхдийн эрхийн тухай конвенцийг оролцуулан хүний эрхийн 29 гэрээ, конвенцийг соёрхон баталсан байна. ХЭК-ийг хэрэгжүүлэгч орны хувьд хууль зөрчсөн насанд хүрээгүй хүнийг зөвхөн гэмт хэрэгтэн гэж үзэлгүй тэднийг хүүхдийнх нь хувьд эрхийг нь хамгаалах хууль зүйн тусгай хамгаалалтыг бий болгох үүрэг хүлээсэн. Сүүлийн арав гаруй жилийн турш Монгол улс үндэсний хууль тогтоомжийг нэгдэн орсон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд, тухайлбал ХЭК-д нийцүүлэн өөрчлөх алхамууд хийсээр, хүүхэд хамгааллын холбогдолтой эрх зүйн хэд хэдэн зохицуулалтыг хэрэгжүүлээд байна. Дараахь 4 хууль гэмт

хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх ажиллагаанд голлон нөлөөлдөг. Үүнд: Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль. Шинэчлэн засварласан Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг холбогдох бусад хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хамтаар 2002 оны 9 дүгээр сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлжээ. Гэсэн хэдий ч Монголын улсын хууль тогтоомжууд нь ХЭК-ийн заалт, зарчимтай бүрэн нийцэж чадаагүй байгаа юм. ХЭК, НҮБ-ын удирдамжинд¹ заасан насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх зарчмуудыг, тухайлбал, эрх чөлөөг нь хязгаарлах арга хэмжээг хамгийн эцсийн арга болгон хэрэглэх, мөн хүүхдийг гэмт хэргийн ертөнцөд дахин орохоос урьдчилан сэргийлэх арга замуудын талаар заасан заалтууд бүрэн тусгалаа олоогүй байна.

Хүүхдийн талаар бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, эрх зүйн шинэчлэл хийж байгаа хэдий ч хуулийн заалт, хэрэгжилт хоёрын заагт дутуу орон зай байсаар байгаа талаар НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо анхааруулсан. Тухайлбал, 18-аас доош насны хүүхдийг урт хугацаагаар урьдчилан хориход саатуулдаг, хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн хүүхдийг хорих ялаар шийтгэдэг, хүүхдэд үзүүлэх эрх зүйн тусламж үйлчилгээ хангалттай биш, хорих болон урьдчилан хорих газрын нөхцөл байдал муу, ял шийтгэгдсэн болон ялаас чөлөөлөгдсөн хүүхдийг эргэн нийгэмшүүлэх ажиллагаа дутмаг, түүнчлэн тэнсэн харгалзах ял шийтгэгдсэн² хүүхдэд төрөл бүрийн бэрхшээл тулгардаг гэх мэт хүлээн зөвшөөрөхөд хүндрэлтэй асуудлууд амьдралд байгааг тэмдэглэжээ. Өнөөгийн байдлаар, ял хойшлуулах, тэнсэн харгалзах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах зэрэг хорих ялыг орлуулах арга хэмжээнүүдийг авч болох талаар хуулинд заасан байгаа ч насанд хүрээгүй хүний хэргийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас гадуур шийдэх, нөхөн сэргээх ажиллагааг хорихоос өөр газарт явуулах талаар хуулийн заалтууд алга байна.

¹ ХЭК зааснаар: Оролцогч улсууд эрүүгийн хууль тогтоомжийг зөрчсөн гэж ялагдан гэм буруутайд тооцогдсон хүүхдэд өөрийнхээ нэр алдар, үнэ цэнээ мэдрэх, хүний эрх, бусдын эрх чөлөөг хүндэтгэн үзэх үзлийг бататгахад дөхөм үзүүлэх, ингэхдээ түүний насны онцлог болон хэлхээ холбоогоо сэргээх, нийгэмд ашигтай үүрэг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхүйцээр харьцахыг шаардах эрхтэйг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь эрүүгийн хууль тогтоомж зөрчсөн гэгдэж ялагдсан буюу гэм буруутайд тооцогдсон хүүхдүүдэд шууд хамаарах хууль журам тогтоох болон тусгай байгууллага, албан газрыг байгуулахад тус дөхөм үзүүлэх бөгөөд шүүн таслах ажиллагаанаас гадуур харьцах хувилбаруудыг бий болгох

² ХЭК /С/15/Нэмэлт.264, р 18, параграф. 66-67.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны хөгжлийн түүхэн товчоо

2000	Хуулийг дээдлэх, шүүх засаглалыг бэхжүүлэх зорилго бүхий шүүхийн эрх зүйн шинэтгэлийн стратеги төлөвлөгөөг Улсын их хурал баталсан.
2001	2001 оны 11 дүгээр сард насанд хүрээгүй хүний хэргийг шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар ажиллах ажлын хэсэг ХЗДХЯ дээр байгуулагдсан. ³ Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулах, улмаар цагдан хоригдож буй хүүхдийн асуудлыг онцгойлон анхаарах нь ажлын хэсгийн гол үүрэг байв. ⁴
2002	Шинэчлэн найруулсан Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, бусад холбогдох хууль, эрх зүйн өөрчлөлт хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэв.
2006	ХЗДХЯ дээр насанд хүрээгүй хүний хэрэг шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн шинэтгэлийн асуудлыг хариуцах ажлын хэсгийг салбарын байгууллагуудын бүрэлдэхүүнтэй байгуулсан. ⁵
	6-р сард Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг сэдэвт зөвлөгөөн зохиогдсон
	7-р сард Ажлын хэсэг туршилтын төсөл хэрэгжүүлэх орон нутгийг сонгосон

³ Төрийн нарийн бичгийн дарга Цэрэндоржоор ахлуулсан энэ ажлын хэсэгт ХЗДХЯ, Прокурорын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, Урьдчилан хорих төв, Насанд хүрээгүйчүүдийн хорих анги, Хүүхдийн төлөө үндэсний төв, Өмгөөлөгчдийн холбоо, Хүний эрхийн үндэсний комиссын төлөөлөл байсан.

⁴ Хууль зөрчсөн хүүхдийн асуудал Монголд, НҮБ-ын Хүүхдийн Сан Монгол, 2002. х 4

⁵ Хууль зүйн шинэтгэлийн ажлын хэсэгт ХЗДХЯ (ахалдаг), Цагдаагийн ерөнхий газар, Дээд шүүх, Нийслэлийн цагдаагийн газар, Улсын прокурорын ерөнхий газар, Өмгөөлөгчдийн холбоо, Хүүхдийн төлөө үндэсний газар, Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын хүүхдийн эрхийн төв (ТББ) багтдаг. Зорилго нь: хүүхдэд ээлтэй эрх зүйн орчин бүрдүүлэх – дараахь үйл ажиллагааг явуулдаг, үүнд: хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар судалгаа хийх, эрх зүйн хүрээг сайжруулах үүднээс хүүхэд хамгаалал, насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх асуудлыг хамаарах эрх зүйн актуудыг боловсруулах, зөвлөмж гаргах; хууль сахиулах байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх (тухайлбал, мэргэжилтнүүд, ажиллагсадад зориулсан сургалтын гарын авлага боловсруулах, баклавр зэрэг эзэмшихээр суралцагсадад академик сургалтын хөтөлбөр боловсруулах); НХХХЭХороог орон даяар байгуулан ажиллуулахыг сурталчилах, нөлөөллийн ажил явуулах; хуулийн нэмэл өөрчлөлт хийх төсөл боловсруулах; салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

	<p>9-р сард НҮБ-ын Хүүхдийн Сан Баянгол, Багануур дүүргүүд болон Хэнтий аймагт загвар хороодыг дараахь зорилготой байгуулахад дэмжлэг үзүүлж эхэлсэн. Үүнд: i) цагдан хорихоос өөр төрлийн олон нийтэд түшиглэсэн арга хэмжээг нэвтрүүлэх; ii) хүүхдийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас хөндийрүүлэх боломжтойг нотлох; iii) эрх зүйн шинэчлэл хийх замаар загварыг түгээн дэлгэрүүлэх⁶</p>
2007	<p>Насанд хүрээгүй хүний хэргийг шийдвэрлэх, байцаан шийтгэх ажиллагааг хүүхдэд ээлтэй хандлагаар явуулах аргачлалын талаар сургагч багш бэлтгэх сургалтыг хууль хяналтын байгууллагын ажилтнуудад зохион явуулсан. Сургалтын гарын авлага боловсруулсан.</p>
	<p>ХЗДХЯ, Дээд шүүх, Хууль зүйн үндэсний төв хамтран Насанд хүрээгүй хүний хэргийг шүүн таслах тухай товхимолыг бэлтгэн тараасан.</p>
2008	<p>Эрүүгийн хуулинд насанд хүрээгүй хүний хэргийг шийдвэрлэхтэй холбогдох бүлэг өөрчлөлтийг хийсэн. 62.1 дүгээр зүйл үүнд орно.⁷</p>
	<p>Орон нутгийн удирдлагын санаачлага, хүсэлтээр Увс, Ховд, Төв, Хөвсгөл аймагт гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороод байгуулагдсан.⁸ Эрх зүйн шинэчлэл хийх баримт бичгийн төслийг Хууль зүйн үндэсний төв боловсруулсан.</p>
	<p>Иргэний бүртгэлийн тухай хуулийн өөрчлөлтийн саналыг Хууль зүйн үндэсний төв боловсруулсан.</p>
	<p>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутнуудын хичээлийн хөтөлбөрт хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай хичээлийг оруулахаар хөтөлбөрийг гарын авлагын хамт боловсруулан, туршсан.⁹</p>

⁶ НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол дахь салбарын хүүхэд хамгааллын хөтөлбөрийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, 2009 оны 3 дугаар сарын 17-ны өдөр

⁷ ХЗДХЯ-ны Гадаад харилцааны хэлтсийн даргатай хийсэн ярилцлага, 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдөр.

⁸ НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол дахь салбарын хүүхэд хамгааллын хөтөлбөрийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, 2009 оны 3 дугаар сарын 17-ны өдөр,


⁹ Монгол улсын Хууль зүйн сургуулийн захирал, багш нартай хийсэн ярилцлага, 2009 оны 3 дугаар сарын 26-ны өдөр

	Хүүхэд хамгааллын мэдээллийн үндэсний сан бий болгох санаачлагын хүрээнд хүүхэд хамгааллын үзүүлэлтүүдийг боловсруулсны дотор гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүнтэй холбогдох үзүүлэлтийг тусгагдсан. Улмаар энэ төслийг хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах үзүүлэлттэй нэгтгэсэн болно.
2009	Туршилтын явцад гарсан үр дүн, ач холбогдол, үр шим, үргэлжлэх чадварыг цэгнэх, хүүхдэд хамааралтай эрх зүйн тогтолцоог сайжруулах стратеги, үйл ажиллагааг төлөвлөх, зөвлөмж боловсруулах зорилгоор төслийн үнэлгээг Улаанбаатар хотын Баянгол, Багануур дүүргүүд болон Хэнтий аймагт хийсэн.

2.2 Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны чиг үүрэг, бүтэц

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны анхны дүрмээр хорооны дүрмийг орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал баталснаар хороог байгуулагдсанд тооцож, үйл ажиллагаа эхэлнэ гэж заажээ. 2006 онд Баянгол, Багануур дүүргийн болон Хэнтий аймгийн иргэдийн хурлын тогтоолоор дүрмийг баталснаар анхны хороод байгуулагдсан байна. Дүрмийн дагуу бие даасан бүтэц, зохион байгуулалт, төсөв, боловсон хүчин, тамга тэмдэг, албан хэргийн захидлын маягтай байлгаж, гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний асуудлыг хариуцуулсан хэдий ч хороо нь бие даасан бүрэн эрхтэй байгууллага биш юм. Хороодын гишүүдийн дийлэнх нь гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн талаар арга хэмжээ авах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын ажилтнууд юм. Зохицуулагч, нийгмийн ажилтан хоёр л орон тооны ажилтнууд бөгөөд ихэнх ажлыг гардан гүйцэтгэж байгаа нь уг бүтцийн сул тал юм. Үйл ажиллагааны заавар, удирдамж, журмыг боловсруулах эрх нь хороонд дүрмээр өгөгдсөн хэдий ч үйл явцын байдал нь тодорхой бус байна. Иймд цаашид дүрмийг шинэчлэхдээ эрх үүрэг, үйл ажиллагааны дэг горимыг тодорхой заах хэрэгтэй. Түүнчлэн, хорооны харъяалал, хамаарлын асуудалд бүхэлд нь анхаарал хандуулж, засаг захиргааны бүтэц дотор хороо хаана нь байх ёстойг тодорхой болговол зохино.

Дараах зураглалаар хорооны дүрмэнд заасан үйл ажиллагааны хүрээг өнөөгийн засаглалын бүтцэд тохируулан үзүүлэв.



Энэ зураглал бодит байдлыг илэрхийлж чадахгүй. Түвшин бүхэнд хэн манлайлах, эзэн байх тухай асуудал тодорхой бус байгаа бөгөөд хариуцлага хүлээх тухайд байдал бүрхэг байна. Хэдийгээр дүрмэнд “ГХХХАХ хороо, түүний салбар нь орон нутгийн засаг даргын удирдлага дор ажиллана. Дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, ажлын албатай байна... Хорооны дарга нь орон нутгийн засаг дарга байх бөгөөд ажлын албаны гишүүд нь ЗДТГ-ын ажилтнууд байна” гэж заасан боловч бодит байдал өөр байна.

Баянгол, Багануур, Хэнтийн аль алинд нь засаг дарга хороог удирддаг гэх боловч Хорооны зохицуулагчдад манлайлах үүргийг шилжүүлж, улмаар НҮБ-ын Хүүхдийн Сангийн төсөл гэсэн хандлага давамгайл байна. Хорооны зохицуулагчийг хороо гэж ойлгож байна. Энэ нь өөр, өөр түвшинд ажилладаг гурван бүлэг бүхий бүтэцтэй хороо болон тодорхой чиг үүрэг бүхий хорооны зохицуулагчийн ялгааг ойлгохгүй байна гэсэн үг юм.¹⁰

¹⁰ Энэ диаграмм НҮБ-ын Хүүхдийн Сангийн Нью Йорк дахь ажлын албаны хүүхэд хамгааллын мэргэжилтэн Анне Гранджины 2008 оны 10 дугаар сард Баянгол, Багануур, Хэнтийд ажиллах үед гаргасан Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны зураг юм. Гишүүнчлэл, гүйцэтгэх үүргийн хувьд практикт зарим ялгаатай зүйл байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороо

Бодлогын баг	Ажлын хэсэг	Хамтарсан баг
<p>41 гишүүнтэй: байгууллагын дарга нар болон хүүхдүүд</p> <p>Зорилго: тухайн орон нутаг дахь хүүхэд хамгааллын асуудлыг (хүчирхийлэл, сургууль завсардалт, гудамжны хүүхэд, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд гэх мэт) хэлэлцэх, хариу арга хэмжээ авах ажлыг зохицуулах</p> <p>Хурал: улирал тутамд</p>	<p>Гишүүд: Цагдаа, прокурор, шүүгч, нийгмийн ажилтан, хүүхэд, эцэг эх</p> <p>Зорилго: хорооны хяналтанд байгаа хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд хууль хяналтын байгууллагатай мэдээлэл солилцох замаар хамтран ажиллаж хэргийг шийдвэрлүүлэх</p> <p>Хурал: шаардлагатай үед</p>	<p>Гишүүд: хэсгийн ахлагч, багш нар, нийгмийн ажилтнууд (сургуулийн, багийн, хорооны, мэргэжлийн сургалтын), гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон нутгийн зөвлөлийн гишүүн</p> <p>Зорилго: шууд хяналт тавих, хүүхэд нэг бүртэй ажиллах</p> <p>Хурал: шаардлагатай үед</p>

2006 онд баталсан дүрэмд уг хороо гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний асуудлаар ямар үүрэгтэйг нарийвчлан заасан байдаг. Хэдийгээр үүрэг заагдсан ч хэн, хэзээ, хэрхэн гүйцэтгэх вэ гэдэг нь тодорхойгүй байна. 41 гишүүний бүрэлдэхүүнтэй хороо нь мэдээж хорооны зохицуулагчаас тусдаа юм. Эдгээр 41 гишүүнээс хэн нь ч зохицуулагч юм уу хамтарсан багийн гишүүний адил хүүхдийг хяналтандаа авч биечлэн тусалдаггүй билээ. Хороо “шийдвэр гаргасан” гэж ярих нь элбэг тохиолдсон боловч үнэндээ зөвлөх үүрэг л гүйцэтгэдэг ажээ. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн хэргийг хуулийн дагуу хууль сахиулах байгууллага шийдвэрлэдэг. Эдгээр нь уансыг сайн ойлгох нь бодит байдлын сул болон давуу талыг дүгнэх, улмаар төслийн үйл ажиллагааг цаашид дэлгэрүүлэн хөгжүүлэхэд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлоход зайлшгүй хэрэгтэй юм.¹¹

Түүнчлэн, хорооны 3 түвшний бүрэлдхүүн болох бодлогын баг, мэргэжилтний ажлын хэсэг, хамтарсан баг одоогийн байгаа хэлбэрээр ажиллахад хэцүү юм. Нэгдүгээрт, гаднаас орж ирж буй санхүүгийн дэмжлэг зогсоход орон нутгийн ажилтнуудаас бүрдсэн ийм бүлгийг тогтвортой ажиллуулах нь бэрхшээлтэй¹² Хоёрдугаарт, мөнгөн урамшуулал олгохоо болиход олон нийтийн

¹¹ НҮБ-ын Хүүхдийн Сангийн ЗАНДБүсийн хүүхэд хамгааллын мэргэжилтэн Шэйли Кэйсийн ажлын тайлан, 2007 оны 10дугаар сар.

¹² Мөн эх үүсвэр.

идэвхтнүүдийн үзүүлж буй үйлчилгээ зогсох магадлалтай ба сайн дурын үндсэн дээр ажиллах хүсэл сонирхлыг бууруулдаг.¹³ Гуравдугаарт, одоогийн бүтцээр үргэлжлүүлбэл байгууллагын эрх хэмжээ, үүрэг хариуцлагыг бүрхэг хэвээр үлдээх бөгөөд мөн тогтолцооны гажуудлыг засахгүй юм. Баянгол дүүргийн хамтарсан багийн гишүүд чиг үүргийн дагуу ажлаа хийгээд урамшуулал авдаг, өөрсдийнх нь цалин хүүхдүүдэд үйлчлэхээр явах унааны мөнгийг ч төлөхөд хүрэлцдэггүй гэж тайлбарлав.¹⁴ Дөрөвдүгээрт, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны дүрмээр хорооны үйл ажиллагааны хүрээг тогтоосон хэдий ч салбар хороо, гишүүн байгууллагууд, зохицуулагчийн ажлыг зааглаж өгсөнгүй, мөн хариуцлага хүлээх холбоосыг гаргаж өгөөгүй байна. Эцэст нь, хорооны хамтарсан баг одоогийн оршин байгаа засаг захиргааны анхан шатны бүтэцтэй хэрхэн, хэр хэмжээгээр уялдаж, эсвэл хоосон орон зайг нөхөж байгаа нь тодорхойгүй байна.

2.3 Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны ажиллагаа

“Олон хүүхдийн амьдралыг аварсан.

Хориход явуулснаар ирээдүйн амьдралыг нь л баллана ш дээ.”¹⁵

Үр дүн: Хороо нь цагдаад саатуулагдах, урьдчилан хоригдох, хорих ял шийтгүүлэх насанд хүрээгүй хүний тоог бууруулах гэсэн үндсэн зорилтоо биелүүлж чадсан байна. Насанд хүрээгүй хүний эрх чөлөөг хязгаарлах нь үр дүнгүй арга гэдгийг олон улсын туршлага харуулдаг. Энэ нь хүүхдийг нөхөн сэргээх үйлчилгээний үр нөлөөг бууруулж, дахин гэмт хэрэг үйлдэх магадлалыг нэмэгдүүлдэг. Төсөл дараах үр дүнд хүрчээ:

- Ω Албадан саатуулагдах насанд хүрээгүй хүний тоо мэдэгдэхүйц буурсан
- Δ Насанд хүрээгүй хүнийг урьдчилан хорих нь бараг зогссон
- Ω Насанд хүрээгүй хүнийг хорих ялаар шийтгэх нь цөөрсөн
- Δ Насанд хүрээгүй хүн байцаан шийтгэх ажиллагааны явцад хамгаалагдах нь ихэссэн

¹³ Мөн эх үүсвэр.

¹⁴ Баянгол дүүргийн хамтарсан багийн 14 гишүүнтэй хийсэн уулзалт, 2009 оны 3 дугаар сарын 30 ны өдөр

¹⁵ Энэ үгийг олон газар, хүүхэд, эцэг эх, нийгмийн ажилтан, цагдаагийн мөрдөн байцаагч, прокурор, олон нийтийн идэвхтэн гээд олон хүн давтан хэлж байсан.

П Насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн тоо буурсан

Ω Рецидивист гэм хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний тоо буурсан

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хорооны ажлын үр нөлөөг мэдрэхэд цаг хугацаа шаардагдах хэдий ч үнэлгээний эхний дүгнэлтээс харахад хүүхдийг цагдан саатуулах, хорих арга хэмжээг олон нийтэд түшиглэсэн хувилбараар орлуулах загварыг цаашид түгээн дэлгэрүүлэхэд боломжийн хэмжээнд суурь нь тавигдсан байна. Хөндийрүүлэх гэдэг нь насанд хүрээгүй хүний хэргийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас гадуур шийдвэрлэх өртөг багатай арга юм. Энэ аргыг хэрэглэснээр ЭБША-ны явцад болон хорих, саатуулах газарт хүүхдэд тулгардаг хүчирхийлэл, дарамтын өндөр эрсдэл, гэр бүл, олон нийтээс тусгаарлагддаг явдал, боловсрол тасалдах болон эрүүл мэндийн үйлчилгээг хүртэхгүй байх, улмаар цаашид ч гэмт хэрэгт сэжиглэгдэх зэргээс сэргийлдэг.

Хүүхдэд гарсан үр дагавар

ХОРООГООР ҮЙЛЧЛҮҮЛСЭН ХҮҮХДҮҮД:	
Мөрдөн байцаалтын шатанд	
	Цагдаагийн ажилтнууд хуулийн дагуу эрхийг танилцуулж хэлдэг болсон
	Мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүх ажиллагааны явцад хууль зүйн туслалцаа авдаг болсон
	Мөрдөн байцаалтын явцад эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, нийгмийн ажилтан, багштайгаа хамт байсан
	Тусгайлан томилогдсон мөрдөн байцаагч, прокурор, шүүгч хэрэг дээр ажилласан
	Цагдаагийнхан* илүү хүндэтгэлтэй ханддаг болсон (хашгирч загнах, цохих, алгадах, чимхэх, зодох, айлгах, дарамтлах явдал харьцангуй багассан)
	НХХХЭХ-ны зохицуулагчийн хүсэлтээр урьдчилан хорихоос батлан даалтанд гаргах болсон
	Хүүхдээс байцаалт авах өрөөнд байцаагдаж цагдаа, прокурор, шүүгчийн зүгээс эелдэг ханддаг болсон
	Мөрдөн байцаалтын* хугацаа богиноссон
	Байцаалтанд байх үедээ сургуульд суралцаж, мэргэжлийн боловсролын хичээлдээ явж, чөлөөт цагийн арга хэмжээнд оролцдог болсон
Шүүх ажиллагааны явцад	
	Өмгөөлөгч оролцдог болсон
	Шүүгч хуулийн дагуу эрхийг нь хэлж өгдөг болсон

	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах шийтгэл оноодог болсон
	Хорих ялыг хойшлуулах зэрэг хорихоос өөр төрлийн ял оноодог болсон
	Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хорооны зохицуулагчийн хяналтанд өгдөг болсон
	Хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хорих ял оногдуулахаас зайлсхийх болсон

Ерөнхий үр дагавар

1

Мэдлэг & хандлага

1990 оноос өмнө насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх комисс гэж байсан бөгөөд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хороо ажилласнаар гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний асуудлыг үндэсний, хот/аймгийн, дүүрэг/сум, хороо/багийн түвшинд дахин гаргаж тавьсан. Насанд хүрээгүй хүний асуудал бүх хамтрагч талуудын анхаарлын төвд орсон байна: Шадар сайдын ажлын алба, ХЗДХЯ, хууль, хяналтын байгууллагууд, Хүүхдийн Төлөө Газар, НХХЯ, орон нутгийн ИТХ, засаг дарга нар, ГХУСЗөвлөлүүд, сургуулиуд, ТББ, олон нийт, эцэг эх, хэвлэл мэдээлэл, их сургуулиуд, иргэд. Загвар төсөл хүүхдэд хэрэгтэй гэдгийг ярилцсан бүх хүмүүс онцолж, дэмжиж байсан. Орон нутгийн засаг дарга, иргэдийн хурлын зүгээс тус хороонд эзэн ёсоор хандах хандлага нэмэгдэж байна. Баянгол дүүргийн Засаг дарга, Багануур дүүрэг болон Хэнтий аймгийн хүүхдийн төлөө хэлтсүүд бодлогын хэлэлцүүлэгт оролцон, улмаар тодорхой зардал хууварилжээ. Хууль зөрчсөн хүүхдийн талаарх олон нийтийн болон албаны хүмүүсийн хандлага өөрчлөгдсөн байна. Тэднийг гэмт хэрэгтэн хэмээн үзэж шийтгэх, бүдүүлэг харьцахыг хэвийн зүйл хэмээн үздэг байснаа өөрчилж хүүхдийг тусгаарлан хорих шаардлагагүй, хүүхдүүд нийгмийн бүлэг дотроо өөрчлөгдөж болох юм гэдгийг ойлгодог болсон.

2

Зан үйл ба үйл ажиллагаа

Хүүхэд хамгаалал, гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний асуудлаар хууль, хяналтын болон нийгмийн хамгааллын салбар хооронд, хүний эрхийн байгууллагууд, олон нийтэд түшиглэсэн бүлгүүд хамтрах, үйл ажиллагаагаа уялдуулах нь илэрхий нэмэгджээ. Аймаг, дүүргийн түвшинд салбар хоорондын ажлын хэсгүүд болон хамтарсан багууд хүүхдэд нэг бүрчилсэн үйлчилгээ үзүүлэн, үр дүнтэй хамтран ажиллаж, хүүхдэд хамаарах асуудлаар хамтын

хэлэлцээнд үндэслэн шийдвэр гаргадаг байна. Хүүхдэд холбогдох хууль, эрх зүйн болон гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний асуудлаар хэвлэлээр цацагдаж буй мэдээллүүд ч объектив хандлагатай болжээ. Хүүхдийн зүгээс гэмт хэрэг үйлдэх шалтгаан, нөхцлийг зөв ойлгож, тэднийг хэрхэн “засч залруулах” арга барилаа мэдэх болсноор нийгмийн зүгээс ялгаварлан гадуурхах нь багасаж байна. Зарим орон нутгийн иргэд хүүхдэд амьдралаа өөрөөр эхлэх боломжийг олгоод зогсохгүй цаашид архагшсан гэмт хэрэгтэн болохоос урьдчилан сэргийлж, нийгмийн амьдралд эргэн ороход нь түшиг дэмжлэг болдог тухай мэдээлж байлаа.

3

Эрх зүйн орчин

Хэдийгээр ХЭК-ийн зарчим болон олон улсын бусад эрх зүйн стандартад бүрэн дүүрэн нийцээгүй ч эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тухай хуулинд 2008 онд хийсэн өөрчлөлтүүд нь гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүнийг хамгаалах, тэдэнд хууль зүйн эерэг орчин бүрдүүлэх тал дээр нааштай ахиц гаргасан байна. НХХХЭХ-ы туршлага хүүхдийг байцаан шийтгэх ажиллагаанаас хөндийрүүлэх нь боломжтой зүйл гэдгийг харууллаа. Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн хөндийрүүлэх арга ажиллагааг дэмжиж эрүүгийн болон байцаан шийтгэх ажиллагааны тухай хууль, бусад холбогдох хуулинд тусгах өөрчлөлтийн саналыг боловсруулжээ.

4

Үр нөлөө

Хамрах хүрээний хувьд төсөл тавьсан зорилгоо даван биелүүлсэн. Дөрвөн аймаг уг төслийг өөрийн нутагт хуулбарлан хэрэгжүүлэх санаачлага гаргаж, НҮБ-ын Хүүхдийн Сангаас техник, арга зүйн дэмжлэг хүссэн бөгөөд Увс, Ховд аймагт зардлыг орон нутгийн төсвөөс хариуцах болжээ.

Дутуу орон зай

Төсөл боловсруулалт: Төслийн эхэнд боловсруулсан үзэл баримтлал байхгүй тул үнэлгээний багийнхан байгууллагын ой санамжид найдан, НҮБ-ын Хүүхдийн Сангийн болон хамтран ажилладаг байгууллагын ажилтнуудтай уулзаж ярилцсан. Хэтийн төлөв, зорилго, зорилт, стратегийн талаар хүүмүүсийн ойлголт зөрүүтэй байлаа. 2007-2011 онд НҮБ-ын Хүүхдийн Сангийн улс орны

хөтөлбөрийн төлөвлөгөөнд тодорхойлсон үр дүнгийн хүрээг харахад ч тайлбар олдсонгүй. Түүнчлэн, төслийн үр дүн, зорилтот бүлэг, шалгуур үзүүлэлтүүдийг томьёолсон нь SMART (тодорхой, хэмжигдэхүйц, хүрэхүйц, хэрэгцээтэй, цаг хугацаатай) бус, төлөвлөсөн үр дүнд хүрэх шат дараалсан, хоорондоо уялдаа холбоо бүхий арга хэмжээг төлөвлөөгүй байна. Тухайлбал, насанд хүрээгүй хүнийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас хөндийрүүлэх стратегийг эрх зүйн өөрчлөлт хийхгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй; үүнийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн улс орны хөтөлбөрийн төлөвлөгөөнд өгөгдсөн үр дүнгийн тоймд тусгаагүй байна.¹⁶ Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хорооны анхны дүрэм нь хэдийгээр зарим зүйлийг чиглүүлсэн боловч зорилго, зорилт, зорилтот бүлэг, хамрах хүрээ, хариуцлагыг тооцох үзүүлэлт зэргийг тодорхой зааж өгөөгүй, ерөнхий заалтуудтай баримт бичиг байна. Дүрмэнд хяналт, үнэлгээ шинжилгээ хэрхэн хийх төлөвлөгөө, тэр тусмаа санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хэрхэн хянах тухай тусгагдаагүй.

Мэдээллийн удирдлагын тогтолцоо: Өөр нэг дутуу орон зай нь цагдаа прокурор, шүүх зэрэг хууль сахиулах байгууллагуудаас гаргасан тоо, баримт мэдээлэл нэгтгэгддэггүй явдал бөгөөд мөн байгууллага тус бүрээс мэдээллийг дэлгэрэнгүй гаргадаггүй байна. Одоогоор, зөвхөн суурь мэдээлэл олдож байна. Тэдгээр нь бүрэн боловсрогдоогүй тул шууд авч хэрэглэх боломжгүй; нас, гэмт хэргийн төрөл, ял оноосон байдал зэргээр нь нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй байх жишээтэй.¹⁷ Хэнтий аймгийн шүүхээс авсан мэдээллээс харахад хууль зөрчөөд шүүх ажиллагаанд оролцсон хүүхдүүдийн нас, хүйс, нутаг, яс угсаа, нийгмийн гарал үүсэл, үйлдсэн гэмт хэргийн төрөл, ял шийтгэл авсан байдлыг мэдэх боломжгүй тоонууд байна. Ямар ял шийтгэлийг ямар төрлийн хэрэгт, хэдэн насны хүүхдэд оногдуулсан вэ гэдгийг мэдэх боломжгүй; эрх чөлөөгөө хасуулсан хүүхдийн тоо, хэдий хугацаагаар эрх чөлөөгөө хасуулсан, хүүхдийн нас, хүйс, нутаг, яс үндэс, нийгмийн гарал үүсэл, эрх чөлөөг нь хасах болсон шалтгаан, түүний үндэслэл зэргийг мэдэх боломжгүй мэдээлэл байна. Мэдээллийн бас нэгэн сул орон зай нь Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд¹⁸ тодорхойлогдсон эмзэг бүлгийн хүүхдүүдийн талаархи нас, хүйс, оршин байгаа газар, боловсрол, гэр бүлийн байдал зэрэг үзүүлэлтийн¹⁹ дагуу боловсруулсан албан ёсны мэдээлэл байхгүй байгаа явдал юм.

¹⁶ 19.2 дахь үр дүнд хүрэхийн тулд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулж Их хурлаар батлуулах ёстой. Гэр бүлийн хүчирхийллийн хувийг заасан үзүүлэлтийг эдгээр хуулиудын хүрээнд авч үзэх хэрэгтэй.

¹⁷ НҮБ-ын Хүүхдийн Сангийн хяналт, үнэлгээ, шинжилгээний ажилтантай хийсэн ярилцлага, 2009 оны Здугаар сарын 17-ны өдөр.

¹⁸ Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11.2.10 дахь заалт

¹⁹ НҮБ-ын Хүүхдийн Сангийн эрх зүйн шинэтгэл төслийн ажилтаны бичгээр өгсөн санал, 2009 оны 3 дугаар сарын 30-ны өдөр.-

Эрсдэлд байгаа хүүхэд: Монгол Улсын Эрүүгийн хуулинд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээх нас 16 бөгөөд зарим хүнд, онц хүнд гэмт хэрэгт 14 нас гэж заасан. Арван дөрвөөс доош насны хүүхдийн үйлдсэн гэмт үйлдлийг хүнд, хөнгөнөөс хамаарахгүйгээр эрүүгийн хариуцлагаас бүрэн чөлөөлдөг. Түүнчлэн, 16-аас дээш насны хүүхэд Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу захиргааны хариуцлага хүлээж болно. Энэ нь торгох, “ухамсарлуулах”, эсвэл цагдаагийн түр саатуулах байранд 7-30 хоног хүртэл хугацаагаар хорих арга хэмжээ байна.²⁰ Дээрхи хоёр бүлгийн хүүхдүүд аль аль нь гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хороонд зуучлагдаж, олон нийтэд түшиглэсэн дэмжих үйлчилгээг авах боломжоор хангагдах ёстой юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ганцаарчилсан арга хэмжээг нийгмийн халамжийн үйлчилгээний нэр дор авч хэрэгжүүлэх нь хэн нэгнийг гэмт хэрэгтэн болох эрсдэлтэй хэмээн “тогтоох” – той харьцуулбал амьдралд арай илүү нийцтэй төдийгүй хэн нэгнийг ялгаварлан гадуурхах явдал гарахгүй байх магадлалтай.

Гэрч, хохирогч хүүхэд: Эрүүгийн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудад хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, албадан хөдөлмөр, дарамт, үл хайхрах зэргээс хамгаалагдах эрхтэйг тодорхой заасан боловч хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргээс хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эсвэл гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах талаар хуулийн болон нийгмийн хамгааллын байгууллага, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хорооноос үзүүлэх дэмжлэг, үйлчилгээ хязгаарлагдмал байна. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд мөрдөн байцаах, шүүн шийтгэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хохирогч, гэрч хүүхдүүдийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тодорхой заагаагүй байна.

Нэгдмэл байдал: Хөтөлбөрүүдийн нэгдмэл байдлыг янз бүрийн түвшинд сайжруулж болохоор байна. Тухайлбал: НҮБ-ын Хүүхдийн Сангийн хүүхэд хамгаалал хөтөлбөр болон Нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөрийн хооронд, мөн НҮБ-ын Хүүхдийн Сан болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хууль зүйн шинэтгэлийн санаачлагын хүрээнд хэрэгжиж байгаа төслийн хооронд гэх мэт. НҮБ-ын Хүүхдийн Сангийн хувьд, Хүүхэд хамгаалал ба Нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөрийн ажилтнууд хамтран үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр, түнш байгууллагууд, зорилтот бүлэг, үйлчилгээний зураглалыг гарган; хамтын ажиллагааны давхцал, огтолцлол, боломжийг тодорхойлно. Түүнчлэн, нийгмийн цогц суурь үйлчилгээ нь хүүхэд хамгаалал болон насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх талаар засгийн газраас аймаг, дүүргийн түвшинд авч хэрэгжүүлж байгаа ажилтай уялдах хэрэгтэй.

²⁰ Хууль зөрчсөн хүүхдийн асуудал Монголд, НҮБ-ын Хүүхдийн Сан Монгол, 2002. х 12

Энэ нь НҮБ-ын Хүүхдийн сангаас тогтолцоонд суурилсан арга замаар хүүхдэд үйлчилгээг хүргэх үндэсний болон орон нутгийн бүтцийг бэхжүүлэхээр ажиллаж байгаа тул чухал ач холбогдолтой.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд эрүүгийн хэргийн ажиллагааны бүх шатанд өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэйг заасан байдаг. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хорооноос санхүүжиж, өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байгаа явдал нь цаашид тогтвортой үргэлжлэх боломжгүйг ойлгож, байцаан шийтгэх ажиллагааны туршид хүүхдэд тасралтгүй, чанартай хуулийн туслалцааг хэрхэн хүргэх талаар бодох нь чухал. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Хууль зүйн үйлчилгээг хүртээмжтэй болгох нь” хөтөлбөрийн хүрээнд авагддаг мэдээллийг (нас, хүйс, хэргийн төрөл, үр дагавар, байрлалаар нь ангилсан) үндэсний түвшинд нэгтгэн боловсруулж, НҮБ-ын Хүүхдийн Сан болон бусад хамтрагч талуудтай хуваалцах хэрэгтэй. Саяхан НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын баталсан НҮБ-ын Хүүхдийн асуудлыг хамаарах хууль зүйн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлэх хэрэгтэй.²¹

Сургамж

Янз бүрийн түвшинд хамтрагч талууд хэд хэдэн сургамжийг авчээ. Энэ хэсэгт хүүхдийг хамгаалах, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бодит үр дүнд хүрэхэд нэмэр болохуйц сургамжуудыг үндсэн зарчим болон сайн туршлагын хамт өгүүлнэ.

Гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд хариуцлага хүлээлгэх нь зүйн хэрэг ч, хариу арга хэмжээ нь хүүхдийн нас, чадамжинд тохирсон байхын зэрэгцээ, тэднийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйл явцыг дэмжсэн, эрхийг нь хүндэтгэсэн ажиллагаа байхыг эрмэлзэх хэрэгтэй.

Хүүхдийн эрх чөлөөг хязгаарлахыг “эхний алхам” болгох нь хатуу чанга, үр дүнд муутай, ач холбогдол багатай арга юм.

²¹ Ерөнхий нарийн бичгийн даргын удирдамж: Хүүхдийн асуудал эрхлэх хууль зүйн тал дээр НҮБ-ын баримтлах бодлого, Байгууллагын санамж бичиг, Ерөнхий нарийн бичгийн даргын ажлын алба, 2008 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр, НҮБ-ын Хүүхдийн Сангийн удирдлаган дор Хуулийн хэлтэс, тэй хамтран хүүхдийн асуудал эрхлэх хууль зүйн асуудал, байгууллагуудын хуулийн мэргэжилтнүүдийн баримтлах журмын талаар хэлэлцсний үр дүнд Хуулийн зохицуулалт, нөөцийн бүлгээс батлан гаргасан.

Хорихыг олон нийтэд түшиглэсэн арга хэмжээгээр орлуулан хэрэглэх нь насанд хүрээгүй хүнийг давтан гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, эргэн нийгэмшихийг дэмжих үр дүнтэй арга гэдэг нь нотлогдсон. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хорооны туршлага нь цаашдаа гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн хэргийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас гадуур шийдэх аргыг нэвтрүүлэх суурийг тавьсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хороо ажиллаж байгаа гурван газарт хууль сахиулах ажиллагааны хүрээнд хүүхдийн хэргийг шийдвэрлэхдээ олон улсын стандартад нийцэхүйц өөрчлөлтүүдийг хийжээ. Үүнд: хүүхэдтэй хатуу ширүүн харьцах байдал цөөрсөн, эрх чөлөөг нь хязгаарлахыг эцсийн арга болгосон, урьдчилан хориход хүүхдийг насанд хүрэгчдээс тусад нь хоридог, эцэг эхэд нь даруй мэдэгддэг, хууль хяналтын байгууллагаас хороонд зуучлах болсон, хорооноос өмгөөлөл, эрх зүйн үйлчилгээнд холбодог, хүүхдээс ээлтэй аргаар байцаалт авах гэх мэт.

Монгол улс насанд хүрээгүй хүний хэргийг шийтгэх тусдаа шүүх заавал байгуулалгүйгээр ХЭК-ийн зарчим, НҮБ-ын удирдамжийг биелүүлж болох юм. Хамгийн гол нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний эрхийг бүрэн хангах явдал хамгийн чухал юм.

Хүүхдийн үзэл бодлыг сонсож, илэн далангүй ярилцан, шүүмжлэн дүгнэхийн өмнө хийсэн үйлдлээ эргэцүүлэх боломж олгох нь хүүхэд сургамж авах, зан байдлаа өөрчлөхөд нь нөлөөлдөг.

Хүүхдийг гэмт хэрэг үйлдэх эрсдэлд хүргэдэг хүчин зүйлс насанд хүрэгчдийнхээс өөр юм. Тиймээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээний үр нөлөө хүүхдэд тусдаггүй.

Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдээ дараах суурь шалтгаануудад анхаарах ёстой. Үүнд: ядуурал, ажилгүйдэл, сургууль завсардалт, гудамжинд амьдрах, эцэг эхийн анхаарал халамж сул, гэр бүлийн тогтворгүй байдал, гэр бүл дэх хүчирхийлэл, эцэг эхийн архидалт, үе тэнгийнхний муу нөлөө, өөртөө итгэлгүй байдал, хөдөөнөөс хотод шилжин суурьшилт, иргэний бүртгэлгүйн улмаас нийгмийн үйлчилгээний гадуур үлдэх, эрх зүйн мэдлэг дутмаг, чөлөт цагаа зөв өнгөрүүлэх арга хэмжээ байхгүй зэрэг юм.

Хууль хяналтын болон нийгмийн хамгааллын салбар урьдчилан сэргийлэх болон дэмжих үйлчилгээнийхээ хүрээг тэлж, улмаар гэмт үйлдэл хийсэн 14-өөс доош насны хүүдүүд, захиргааны зөрчил гаргасан 16-аас дээш насны хүүхэд, гэрч болон хохирогч хүүхдийг хамруулах хэрэгтэй.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг аль нэг байгууллага дангаараа хариуцаад үр дүнд хүрэх боломжгүй. Гэр бүлийг болон олон нийтийг чадавхижуулах нь хүүхдийг эргэн нийгэмших, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажиллагааны цөм болдог.

Орон нутгийн удирдлага болон мэргэжлийн ажилтнаас хүүхдэд үзүүлэх үйлчилгээнүүдийн хоорондын уялдаа холбоог сайтар хангаж, зохион байгуулалттайгаар хүргэх бөгөөд амьдрах ухааны сургалтанд хамруулах, мэргэжлийн ба албан бус боловсрол олгох, чөлөөт цагийн арга хэмжээ, эрх зүйн туслалцаа үзүүлэх, үе тэнгийнхний дэмжлэг авах, мэдээлэл солилцох боломжийг олгох ёстой.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хороо нь байгууллагын стандартыг боловсруулж, хариуцлага тооцох механизм (тухайлбал: цагдаагийн ажилтан, урьдчилан хорихын хянагч нарын мөрдөх ёс зүйн хэм хэмжээ гэх мэт), үйлчилгээний жишиг (тухайлбал: тэнцэн харгалзах ялтай хүүхэдтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний стандарт) зэргийг бий болгох хэрэгтэй бөгөөд хүүхдэд ээлтэй хандлагаар тайлагнах, хяналт үнэлгээ хийх, хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэх хэрэгтэй.

Насанд хүрээгүй хүний хэрэг шийдвэрлэх, улмаар хүүхэд хамгааллын асуудлын хүрээнд үйлчилгээг хүргэх, хамгаалах талаар хуулийн болон нийгмийн хамгааллын салбар хоорондын салангид үйл ажиллагааг нэгдмэл байлгах талаар Засгийн Газрын хэрэг эрхлэх газар арга хэмжээ авах нь зүйтэй.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хороо нь тэнд ажиллаж буй хувь хүмүүсийн хичээл зүтгэл дээр тогтож байгаа нь цаашид тогтвортой үргэлжлэх боломжгүйг харуулж байна. Хорооны оролцогч талуудын үйл ажиллагааны заавар, протоколыг боловсруулах; үүрэг, хариуцлагыг тодорхойлох; үйлчилгээний стандарт, журмыг бий болгож мөрдөх хэрэгтэй.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хороо, баг хорооны нийгмийн ажилтан болон хууль хяналтын байгууллагуудын ажил үүргийн хуваарилалт нь хүүхдэд үзүүлэх үйлчилгээний чанар, үр дүнд шууд нөлөөтэй. Иймд хот, аймаг, дүүрэг, хороо, багийн түвшинд хэн ямар үүрэгтэй, юу хийдэг, үр дүнтэй үйлчилгээг хүргэхэд тулгарч буй бэрхшээл юу байдаг зэргийг нарийвчлан судлах шаардлагатай.

3. ЗӨВЛӨМЖ

3.1 Нийтлэг зөвлөмж

Энэхүү хэсгийн зөвлөмжийг НҮБ-ын Хүүхдийн Сангаас Монгол Улсын Засгийн Газартай хамтран хэрэгжүүлж буй (~2011) болон цаашид хэрэгжүүлэх (2012-2016) хөтөлбөрийн хугацааг хамруулан боловсрууллаа.

Зөвлөмж: Монгол улсад хүүхдийн хууль зүйн хэтийн төлөв, зорилгыг хамтрагч талууд нухацтай хэлэлцэн, оролцооны зарчимд үндэслэн тодорхойлох шаардлагатай.

Хэтийн төлөв нь улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдалд тохирсон, хэрэгжих бодит үндэслэлтэй байх ёстой.



Түүнчлэн, төслийн тухайлсан зорилго, зорилтоос өргөн хүрээнд томъёологдсон, аль нэг байгууллагын эрх хэмжээт үүрэг, тэргүүлэх чиглэлээр хязгаарлагдахгүй, алсыг харсан буюу 2016 он хүртэл үйлчлэх байдлаар тодорхойлогдох нь зүйтэй.

Ингэхдээ, үндэсний хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн хууль зүйг хөгжүүлэх, шударга ёсыг хангах загвар болох ёстой. Энэ нь зөвхөн эрүүгийн эрх зүйн тогтолцооны хүрээнд авч үзэхүйц бус, өргөн агуулга бүхий асуудал бөгөөд хүүхэд, гэр бүлд үйлчилдэг нийгмийн хамгааллын тогтолцоо, хүний эрхийн болон хүүхдийн эрхийн байгууллагуудыг хороо, багаас эхлэн үндэсний түвшинд хүртэл бэхжүүлэх зэргийг хамаарна.

Эцэст нь хэлэхэд, хэтийн төлөв нь стратегийн чиглэл, ирээдүйн чиг хандлага, хөтөлбөрийн үндэслэл болох ёстой. "Хүүхдийн хууль зүй"-н хэтийн төлөвийг цогц байдлаар тодорхойлох, тогтолцоо бий болгох талаар хамтрагч талууд нэгдмэл ойлголттой байх нь хүүхэд хамгааллыг бэхжүүлэх ажлын гол суурь нь байх болно. Хэтийн төлөв нь Монгол Улсын Хүүхэд хамгааллын стратегийн²² үзэл санаанд нийцсэн байх ёстой. Энэхүү тайланд зөвлөмж боловсруулах үүднээс хэтийн төлөвийг дараах байдлаар тодорхойлов: Монгол улсад бүх хүүхэд хүүхдэд ээлтэй хууль, эрх зүйн орчинд хамгаалагдан, үйлчилгээ нь хүртээмжтэй, чанартай байж, нийгмийн хамгааллын тогтолцоо, хүний эрх, хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах байгууллагууд уялдаа холбоотой ажиллана.

²² Монголын засгийн газарт батлуулахаар өргөн барьсан, хүлээгдэж байгаа

3.2 Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг эрхлэх хороог үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх

Зөвлөмж: Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороог үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажлыг (i) эрх зүйн шинэтгэл хийх, (ii) тус хорооны шинэчлэгдсэн загварыг бусад орон нутагт байгуулах гэсэн бие биеэ дэмжсэн хоёр замаар хэрэгжүүлнэ.

2009-2016 онд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны загварыг үндэсний хэмжээнд дэлгэрүүлэх зорилгыг дэвшүүлэн ажиллах хэрэгтэй. 2010-2012 онд одоогийн байгаа хороодын үйл ажиллагааг цэгцлэн стандартчилж, бүтэц ба хүрээг тогтоон, кейс менежментийн заавар ба маягтууд, үйл ажиллагааны удирдамж, журмыг боловсруулах хэрэгтэй. 2010 онд засгийн газрын хэрэг эрхлэх газар, орон нутгийн засаг дарга нар, гол хамтрагч талуудын оролцоотойгоор НҮБ-ын Хүүхдийн Сангийн техник туслалцааг авч үйл ажиллагааны стратегийг боловсруулан, орон нутгаас эхлэн үндэсний хэмжээнд хүртэл хэрхэн ажиллах талаар нарийвчилсан төлөвлөлт хийх шаардлагатай. Ингэхдээ, арга зүй, үйл явц, хариуцах эзэн, гүйцэтгэх цаг хугацааг тодорхой тусгана. Зардлыг хуваалцах, мөнгөн бус хэлбэрийн дэмжлэг үзүүлэх, хяналт үнэлгээ хийх нь (жишээ нь: зорилго, зорилтот бүлэг, хүүхдийн хамгааллын мэдээллийн үзүүлэлтүүд) энэ төлөвлөгөөний нэг хэсэг нь байх ёстой.

Увс, Ховд, Хөвсгөл, Төв зэрэг дөрвөн аймагт шинээр байгуулагдсан хороодыг шинэчлэгдсэн загвараар хөгжүүлэхэд НҮБ-ын Хүүхдийн Сангийн техникийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай. Үйлчилгээнд ашиглагддаг маягтууд, албан бичгийн болон гэрээний загварууд, кейс баримтжуулалт, хяналт үнэлгээний хэрэгслүүд, санхүүгийн маягтууд, эвлэрүүлэх үйл ажиллагааны заавар, журмыг шинэ хороодод нэвтрүүлэх ёстой. Түүнчлэн, шинээр байгуулагдах хороодод зориулан ажлын байранд болон дагалдуулан сургах ажлыг зохион байгуулж, зохих арга зүйн материалуудыг бэлтгэн танилцуулна.

Насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, орон нутгийн хэрэгцээ, нөөц боломжийг тодорхойлох нь хорооны үйл ажиллагааг үргэлжлүүлэн тэлэхдээ анхаарах нэн тэргүүний асуудлууд болон зорилгоо тодорхойлоход туслах юм. Дүрэм, журмуудыг нийцүүлэн өөрчилж, эсвэл дахин боловсруулж орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар, эсвэл засгийн газраар батлуулах хэрэгтэй.

3.3 Манлайлал ба эзэн байх

Зөвлөмж: Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороог хэн манлайлах, хэн эзэн нь байх асуудлыг тодорхой болгож, анхан шатнаас үндэсний хэмжээнд хүрэх бүх шатанд хэрэгжүүлэх, удирдахтай холбоотой үүрэг, хариуцлагыг нарийвчлан заавал зохино. Хорооны үйл ажиллагааны бүх түвшинд оролцогч талуудын хүлээх үүргийг хянах, ил тод байдлыг хангах механизмыг тодорхой болгох шаардлагатай юм.

Үндэсний түвшинд Засгийн Газрын хэрэг эрхлэх газар манлайлж, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлыг эрчимжүүлж, засаг даргад гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны ажлыг удирдлагаар хангах ажлыг даалгана. Засгийн Газрын хэрэг эрхлэх газар, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг дарга (доорх зураглалд улаанаар хүрээлэн харуулсан) нар хорооны үйл ажиллагааг хариуцаж, жил бүр засгийн газар болон бусад холбогдох байгууллагад тайлагнана.


Засгийн газрын хэрэг эрхлэх газар, орон нутгийн иргэдийн хурал, засаг дарга нар манлайлах үүргийг гүйцэтгэж байхад орон нутгийн болон үндэсний түвшинд бусад байгууллагууд хорооны үйл ажиллагааг эрхлэн явуулах (доорх зураглалд үзмэн ягаан өнгөөр хүрээлэн харуулсан) эзэн нь байна. Үндэсний болон орон нутгийн түвшинд гол үүрэг хүлээгчдийн гүйцэтгэх тусгайлсан үүрэг, хариуцлагыг тодорхой болгон заах хэрэгтэй. Хэрэг эрхлэх газар нь яамд, орон нутгийн захиргааны ажилд шууд хяналтыг хэрэгжүүлдэг нь хороог ажиллуулахад чухал үүрэгтэй.

ХТҮГ-ын хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн бодлого боловсруулах, нөлөөллийн ажлыг удирдан явуулах, салбар хоорондын зохицуулалтыг дээрээс доош, доороос дээш хийх үүргийг хуулинд зохицуулалт хийх замаар тодруулж болон практикт бодитой хэрэгжих боломжтой болгох хэрэгтэй.

НҮБ-ын Хүүхдийн Сангийн үүрэг нь техникийн туслалцаа үзүүлэх, чадавхи бэхжүүлэх, шаардлагатай тохиолдолд санхүүгийн дэмжлэгийг Засгийн Газрын хэрэг эрхлэх газар болон засаг дарга нарт үзүүлэх зэргээр хязгаарлагдах ёстой. Санхүүгийн дэмжлэгийг аажмаар багасган 2016 он гэхэд улсын төсвөөс бүрэн санхүүжилт хийгдэх хэмжээнд хүрсэн байна.

Дараах зураглалд Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны ажиллах бүтцийг одоогийн оршин байгаа бүтцийн хүрээнд (хэдий тийм сайн бүтэц биш хэдий ч) үндэсний болон орон нутгийн түвшинд хэрхэн холбогдон ажиллахыг үзүүллээ. Улаанаар хүрээлэгдсэн байгууллагууд удирдан чиглүүлэх, тайлагнах үүрэг бүхий манлайлалыг; үзмэн ягаанаар хүрээлэгдсэн

байгууллагууд товчоог ажиллуулах, хэрэгжүүлэх үүрэгтэй эзэн байна. НҮБ-ын Хүүхдийн Сан манлайлах үүрэг гүйцэтгэхгүй ба Засгийн Газрын хэрэг эрхлэх газар, засаг дарга нар, яамдыг манлайлах үүргээ биелүүлэхэд нь, Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороог зохицуулах үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Хорооны харилцаа, холбоо, тайлан, мэдээ баримт, мэдээллийг түгээх арга зүй, журмыг боловсруулах хэрэгтэй.



3.4 Судалгаа, баримт нотолгоо

Зөвлөмж: Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүн, гэрч, хохирогч хүүхдийн талаар үндэсний статистикийн тогтолцооны хүрээнд мэдээлэл цуглуулж, бүх мэдээлэл үзүүлэлтийг ХЭК болон НҮБ-ын удирдамж, журмуудыг хэрэгжүүлэх; бодлого хөтөлбөр, төсөл боловсруулах болон хяналт, үнэлгээ шинжилгээ хийхэд ашиглах; мэдээллийг түгээх, олон нийтэд хүргэхэд шинэ арга барилаар хандах²³ хэрэгтэй. Энэ нь хүүхэд хамгааллын үндэсний мэдээллийн сан бий болгох НҮБ-ын Хүүхдийн Сан, Засгийн Газрын хамтарсан санаачлагатай зэрэгцээ хийгдэх ёстой.

Нийгмийн төсөвлөлт

Зөвлөмж: Эдийн засаг, нийгмийн бодлоготой уялдсан хүүхдэд ээлтэй төсвийг боловсруулах шаардлагатай бөгөөд ингэснээр хүүхдийн хамгаалагдах эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах зарим орон зайг нөхөх юм. Үүний тулд дараах үр ашгийн тооцоог хийж болно:

- Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны зардлыг урьдчилан хорих, баривчлан саатуулах, хорих ял шийтгэх, болон хэрэг бүртгэх мөрдөн байцаах шатнаас эхлээд шүүн шийтгэх, ял хойшлуулах, нийгэмд эргэн нэгтгэх бүх ажиллагаанд зарцуулах өртөгтэй харьцуулах
- Хөнгөн, хүндэвтэр гэмт хэргийг хөндийрүүлэх аргаар шийдвэрлэхэд шаардагдах зардлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад цагдаа, прокурор, шүүх, өмгөөлөгчийн зарцуулах цаг, хүч, хөрөнгө болон бусад нийгмийн халамжийн үйлчилгээний зардалтай харьцуулан судлах

Баримт, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх ажиллагаа

Зөвлөмж: Хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл, шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийн талаар нарийвчилсан судалгаа хийж, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх, цогц стратеги боловсруулах хэрэгтэй. Хүүхдийг гэмт хэрэг үйлдэх эмзэг байдалд хүргэж эсвэл хүүхдийг гэмт хэргийн хохирогч болгож байж болзошгүй хүчин зүйлсүүд буюу ядуурал, гэр бүлийн таагүй уур амьсгал, ажилгүйдэл, чөлөөт цагийн болон танин мэдэхүйн арга хэмжээ дутмаг байдал, жендерийн тэгш бус байдал, санхүүгийн хүндрэл бэрхшээл, улс дотроо болон улсууд хоорондын ялгаатай байдал зэргийг судлах ёстой. Ямарваа урьдчилан сэргийлэх ажиллагаа хэн хийвэл илүү үр дүнтэй байх вэ гэдгийг тунгааж гэр бүл, багш, нийгмийн ажилтан, хууль, хяналтын

²³ Хүүхдийн эрхийн хорооны Монголд өгсөн зөвлөмж, ХЭК/С/15/Add.264, 2005 оны 9 дүгээр сарын 21, х 5-6.

байгууллагын ажилтнууд гэх мэт хүмүүсийн үүргийг судлана. Үндэсний болон орон нутгийн түвшинд хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд буй сайн болон үр дүнгүй туршлагыг баримтжуулж байх ёстой. Судалгааны үр дүнд үндэслэн зан үйлийн өөрчлөлтийг дэмжих арга хэмжээг сонгосон зорилтот бүлэгт явуулах юм.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хувь хүн хоорондын харилцаа ба мэдэллийн хэрэгслийн үүрэг чухал ач холбогдолтой гэдгийг тэмдэглэн хэлэх хэрэгтэй. Хэвлэл, мэдээллийн компани ажил болон зан үйлийн өөрчлөлтийг дэмжих үйл ажиллагаа нь зорилтот бүлгийн ойлголтыг тодорхой нэг асуудлаар нэмэгдүүлэх, улмаар хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн иргэд өөрсдөө авч хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлдэг.

3.5 Хүүхдийн Эрхийн Конвенцийн зөвлөмжүүд

Зөвлөмж: Хүүхдийн Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороо мөн дэмжих ёстой. Үүнд:²⁴

- А. Насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх чиглэлээр үндэсний цогц хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, ингэхдээ шүүгчдийг дагнан мэргэшүүлэх, мэргэшсэн боловсон хүчин бүхий нүүхийг аймгуудад байгуулах
- Б. 18-аас доош насны хүүхдийн эрх чөлөөг хязгаарлах хугацааг хуулиар хязгаарлах
- В. 18-аас доош насны хүүхдийг урьдчилан хорих хугацааг хуулиар хязгаарлах, шаардлагатай тохиолдолд сүүлийн арга хэмжээ болгон хамгийн богино хугацаагаар хорих, шүүхээс хэргийг шийдвэрлэх хугацааг түргэвчлүүлэх, явцын туршид хяналт тавих
- Г. 18-аас доош насны хүүхдийн эрх чөлөөг хязгаарлахын оронд тэнсэн харгалзах, ял хойшлуулах, олон нийтэд тустай ажил хийлгэх зэрэг хувилбараар шийдвэрлэх
- Д. Хорихоос өөр төрлийн арга хэмжээ авах боломжгүй тохиолдолд үүнийг эцсийн арга хэмжээ болгон ашиглахдаа баривчлах, хорих ажиллагааны журам, хорих газрын нөхцлийг сайжруулах

²⁴ Хүүхдийн эрхийн хорооны Монгол орны нөхцөл байдалд хийсэн дүгнэлт, ХЭК/С/15/Add.264, 2005 оны 9 дүгээр сарын 21, х 18-19

- Е. 18-аас доош насны хүүхэд зохих өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах; санал, гомдол мэдүүлэх механизм нь хүүхдэд нь мэдрэмжтэй, үр дүнтэй байхад анхаарах
- Ё. Насанд хүрээгүй хүний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцогсдыг тухайн чиглэлийн олон улсын стандартын талаар сургах, хүүхдийн хориход нийгмийн ажилтны орон тоог бий болгосноор хүүхдэд дэмжлэг үзүүлэх
- Ж. Ял шийтгүүлсэн болон хорихоос суллагдсан 18-аас доош насны хүүхдэд боловсрол олгох, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, амьдрах ухааны сургалтанд хамруулах боломж бүрдүүлэх, улмаар нөхөн сэргээх, нийгэмшүүлэх арга хэмжээнд оролцуулах замаар хөгжлийг дэмжих
- З. НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба мансуурах явдалтэй тэмцэх байгууллага, НҮБ-ын Хүний Эрхийн дэд комиссарын газартай хамтран ажиллах, тэднээс техникийн дэмжлэг авах

3.6 Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны үзэл баримтлалын өөрчлөлт || 2012-2016 ||

Нөлөөлөл

Зөвлөмж: 2010-2012 онд НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн, Хүүхдийн төлөө Газар болон бусад хамтрагч байгууллагууд “Хүүхдийн Хууль Зүй”-н үзэл баримтлалыг дэмжих нөлөөллийн ажлуудыг төлөвлөх, хууль зүйн болон нийгмийн хамгааллын салбарын гол мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай. Ингэснээр, 2012-2016 оны хөтөлбөрийн төлөвлөлтийн бэлтгэл болох төдийгүй одоогийн Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны чиг үүрэг, хамрах хүрээг тэлж Хүүхдийн Хууль Зүйг хөгжүүлэх ажлын эхлэл болно.

Чиг үүрэг, хүрээ, бүтэц²⁵

Зөвлөмж: 2014 оноос эхлэн Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх

²⁵ НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын удирдамжийг харна уу: Хүүхдийн хууль зүйн асуудлаархи НҮБ-ын байр суурь, байгууллагын дотоод баримт бичиг, Ерөнхий нарийн бичгийн даргын ажлын алба, Монголын хүүхэд хамгааллын стратегийн баримт бичгийн төсөл, (батлагдахаар хүлээгдэж байгаа), 2009; 2008 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр; Хүүхэд хамгааллын гарын авлагын хүүхдийн төлөө хууль зүй хэсэг, Бангкок, НҮБХС, ЗАНДБА, 2009 оны 1дүгээр сар, НҮБ-ын эдийн засаг, нийгмийн зөвлөл, 2005 оны 5-дугаар сарын 25, Гэрч, хохирогч хүүхдүүдийг хамгаалах хууль зүйн удирдамж, E/CN.15/2005/L.2/Rev.1.

хорооны одоогийн нэр, чиг үүрэг, зорилтот бүлэг, ажлын хүрээ, бүтцийг дараахь байдлаар өөрчлөхийг зөвлөж байна: ²⁶

Нэр: Хүүхдийн хууль, эрх зүйн хороо

Чиг үүрэг: Хүүхэд бүр хүүхдэд ээлтэй хууль зүйн орчинд хамгаалагдах; гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, гэрч, хохирогч хүүхдүүд болон бусад халамж, хамгаалал шаардлагатай хүүхдүүдэд нийгмийн хамгааллын тогтолцоо, үндэсний хүүхдийн эрхийн болон хүний эрхийн байгууллагуудын үйлчилгээ нь хүртээмжтэй, чанартай байх явдлыг хангана.

Зорилтот бүлэг: Дараахь бүлгийн хүүхдэд үйлчилнэ: 1). Захиргааны зөрчил болон гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, 2). Хүчирхийлэл, дарамт, үйл хайхрах, хүн худалдаалах, хүүхдийн хөдөлмөр, мөлжлөг зэрэг гэмт хэргийн хохирогч хүүхэд 3). Хүчирхийлэл, дарамт, үйл хайхрах, хүн худалдаалах, хүүхдийн хөдөлмөр, мөлжлөг зэрэг гэмт хэргийн гэрч хүүхэд

Хамрах хүрээ: Хүүхдийн хууль зүйн хороо нь хууль зөрчсөн хүүхэд, гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулна.

Урьдчилан сэргийлэх, үйлчилгээ үзүүлэх бүх ажлыг ХХЗХорооны зохицуулагч хариуцна гэсэн үг биш бөгөөд мөн зэрэгцээ бүтэц, үйлчилгээ бий болгоно гэсэн санаа агуулаагүй гэдгийг тодотгон ойлгох хэрэгтэй. Харин эсрэгээр, ХХЗХорооны зохицуулагч нь хүүхдийг гэмт хэргээс (хүүхэд үйлдсэн болоод хүүхдийн эсрэг үйлдэгдсэн) урьдчилан сэргийлэх болон хүүхэд хамгаалах үйлчилгээ хүргэж буй бүтцийн чадавхийг бэхжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, хяналт үнэлгээ хийх зэрэгт дэмжлэг үзүүлэн, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах зохицуулалт хийх үүрэгтэй байна. Хууль зөрчсөн хүүхдийг “хяналтандаа авах”-аас өөр төрлийн шууд туслалцаа, үйлчилгээг ХХЗХорооны зохицуулагч үзүүлэхгүй. Сонирхлын зөрчил гарч болзошгүй тул зохицуулагч өмгөөлөгчийн үүрэг гүйцэтгэж таарахгүй. Харин өмгөөлөгч нарыг хүүхдэд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх, байцаан шийтгэх ажиллагаанд үр бүтээлтэй оролцоход дэм үзүүлж чадавхийг нь бэхжүүлнэ. ХХЗХорооны

²⁶ Ерөнхий нарийн бичгийн даргын Хүүхдийн хууль зүйн талаар өгсөн зөвлөмжийг харна уу, Байгууллагын дотоодын зөвлөмж бичиг, ЕНБДА, 2008 оны 9 дүгээр сарын 2, Хүүхдэд хамгааллын стратеги, Хүүхдийн хууль зүй, Бангкок, НҮБХС, ЗАНДБА, 2009 оны 1 дүгээр сар, НҮБ-ын нийгэм, эдийн засгийн хороо, 2005 оны 5дугаар сарын 25, Хууль зүйн хүрээнд хохирогч, гэмт хэргийн гэрч хүүхдүүдийн хэргийг хянан шийдвэрлэх удирдамж, E/CN.15/2005/L.2/Rev.1.

зохицуулагчийн ажлын байрны тодорхойлолт дээрх үүргүүдийг тусгасан байдлаар өөрчлөгдөх ёстой.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хорооны зохицуулагч ба хороо нь нэг утгатай биш гэдгийг сайтар санаж байвал зохино. Үүнтэй адил, ХХЗХороо нь түүний зохицуулагч биш бөгөөд хороо нь хуулийн, нийгмийн хамгааллын, хүүхдийн эрхийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ. Одоогийн чиг үүргийн дагуу хорооны гишүүд гэмт хэрэг, хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах зэргээс урьдчилан сэргийлэх, мөн хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдэд хамгаалах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Иймд ХХЗХороо нь хүүхдэд ээлтэй хууль зүйг дэмжин ажиллах хамтын ажиллагааны сүлжээг албажуулж буй хэрэг болохоос бус шинэ үүрэг, шинэ хариуцлага биш юм.

ХХЗХорооны зохицуулагч нь хорооны ажлын уялдаа холбоог хангах, зохицуулах, зөвлөх, техникийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Хууль зөрчсөн болон гэрч, хохирогч хүүхдийн асуудлаар урьдчилан сэргийлэх болон хамгаалах үйлчилгээ үзүүлдэг хууль зүй, нийгмийн хамгаалал, хүүхдийн эрхийн байгууллагуудын үйл ажиллагаа нь бие биенээсээ харилцан хамааралтай тул тэдгээрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэй юм. Жишээлбэл, хууль зөрчсөн хүүхэд хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдлын золиос байж болно. Иймд хүүхэд хамгааллын тогтолцоог үр дүнтэй, урт хугацаанд, тогтвортой ажиллаж чадахуйц байдлаар бий болгох хэрэгтэй.

Бүтцийн хүрээ: Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал эрхлэх хороо дотроо 3 дэд багтай: бодлогын баг, ажлын буюу мэргэжилтний баг, хамтарсан баг. Үүнийг тэр хэвээр нь хуулан авахын өмнө анхан шатанд баг, хороонд, сум дүүрэгт, аймагт, хотод хэн юу хариуцдаг, ямар зохицуулалттай, үр дүнтэй үйлчилгээ хүргэхэд чухам юу саад болдог, ямар хүчин чадавхи байгаа зэргийг харахуйц зураглал хийж үзэх хэрэгтэй.

Ингэснээр зарим нэгэн давхцлыг олж харах боломжтой болно. Тухайлбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, орон нутгийн хүүхдийн зөвлөл, олон нийтэд түшиглэсэн бусад байгууллагын үйл ажиллагааг харна. Хэрэв эдгээр зөвлөл, байгууллагын гишүүнчлэл нь энэхүү тайлангийн зөвлөмжийн дагуу өөрчлөгдөн зохион байгуулагдах ХХЗХорооны гишүүнчлэлтэй давхцаж байвал тэднийг нэгэн цул болгон зохион байгуулж болно. Энэхүү бүрэлдхүүнийг ХХЗХороонд холбон албажуулж, ямар үүрэг гүйцэтгэх, ямар үйл ажиллагаа явуулах, хариуцлагын тогтолцоо ямар байх, хүүхдийн хууль зүйг хэрхэн бэхжүүлэх зэргийг тодорхой болгоно. ХХЗХорооны бүрэлдхүүн дээр өгүүлсэн зураглалд үндэслэн хийгдэх ёстой. ХХЗХороо хэрвээ байгуулагдвал, зорилго, гишүүнчлэл, үүрэг, хариуцлага, шийдвэр гаргах зарчим, ирц, шийдвэрийг эргэн хянах, зөрчлийг зохицуулах, уулзалт хийх журам, ажлын албаны ажиллах горим зэргийг эхлээд тодорхой болгох хэрэгтэй.

Хяналт, үнэлгээ

Зөвлөмж: Хүүхдийн хууль зүй хөтөлбөрийн салшгүй хэсэг нь хяналт үнэлгээ шинжилгээний ажил байх ёстой. Зарим анхаарах зүйлийг дурдвал:

Үзүүлэлтүүд

- Хүүхэд хамгааллын мэдээллийн үндэсний санд суурилан үзүүлэлтүүдийг сонгох ба энэ нь үйл явцын түвшинтэй (үр дүн, үр нөлөө, үр дагавар) тохирч байх ёстой
- Зорилтот бүлэг, хамрах хүн амыг тодорхойлох ёстой
- Үзэл баримтлал, нэр томъёог тодорхойлох ёстой
- Мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох ёстой

Суурь мэдээлэл

- Хэрэгтэй мэдээллийг цуглуулах
- Мэдээлэл цуглуулах хэрэгсэл, аргачлалыг боловсруулах
- Хугацаа тогтоох
- Хүний нөөцийг чадавхижуулах

Мэдээлэл цуглуулах ажлыг төлөвлөх

- Үзүүлэлтийн дагуу хянахын тулд хөтөлбөрийн туршид хэрэгцээтэй мэдээллийг цуглуулна.
- Мэдээлэл цуглуулах арга, хэрэгслийг ашиглана.
- Мэдээлэл цуглуулах давтамжийг тогтооно.
- Мэдээлэл цуглуулах үүрэгтэй хүнийг томилно.
- Мэдээлэл цуглуулах явцад зохицуулалт хийнэ.
- Мэдээлэл цуглуулах ажлыг төлөвлөгөөнд тусгана.
- Төв, орон нутгийн төрийн байгууллагын үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах төлөвлөгөө

- Мэдээллийг боловсруулах давтамжийг тогтооно.
- Мэдээлэл боловсруулах үүрэгтэй хүнийг тогтооно
- Мэдээлэл боловсруулах хэлэлцүүлэгт ажиллагсад, хамтрагсдыг оролцуулна.

- Мэдээллийн үр дүнг танилцуулна.
- Мэдээлийн дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргах эрх бүхий хүнийг тогтооно, хөтөлбөрт өөрчлөлт хийхийг мөн авч үзнэ.
- Ажилтнууд, түншлэгчид, хамтрагсад, хандивлагчдын харилцаа холбоог тодорхойлно.
- Төв, орон нутгийн төрийн байгууллагын үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

Зохицуулалт, хамтын ажиллагаа, уялдаа холбоо

Зөвлөмж: Зохицуулалт, хамтын ажиллагаа, уялдаа холбоог бий болгох хамгийн эхний алхам бол төвийн болон орон нутгийн түвшинд байгаа хүүхдийн хууль зүйтэй холбогдолтой бүх бүтэц, үйлчилгээг багтаасан зураглал гаргах хэрэгтэй. Энэ нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн бүх шатны байгууллагуудын бүтэц, уялдаа, харилцааг харуулсан зураглал болно.

Зураглалаар ХТҮЗ ба ХТҮГ, ХТҮГ ба нийгмийн хамгааллын байгууллагууд хоорондын үйл ажиллагаа, бүтцийн нарийн зааг ялгаа, хариуцлагын холбоосыг тодруулах болно. Түүнчлэн, үйлчилгээ нь олон улсын стандартыг хангаж байгаа эсэх, сул болон давуу талыг судална.

Доорхи зурагт бүтцийн зураглалыг зөвхөн түвшин болон үүргээр бус, мөн үйл ажиллагааны явц бүрт хэн ямар үүрэгтэй, яаж холбогдон ажиллаж болох чиглэлийг үзүүлээ.

Насанд хүрээгүй хүний хэрэг эрхлэх хууль, эрх зүй: Бүтэц, үүрэг, үйл явцыг тодорхой болгох




Хэн манлайлдаг? Гүйцэтгэдэг? Хариуцдаг? Хэрхэн хамтардаг?

Хууль зүйн тогтолцоо
ХЗДХЯ
Дээд шүүх, шүүгчид

НХ тогтолцоо
НХХЯ

Бусад
ХТҮГ
ХТҮЗ
ХЭҮК
БСШУЯ
Засаг дарга

Гэрч, хохирогч хүүхэд Бүтэц, үүрэг, үйл явцыг тодорхой болгох



Хэн манлайлдаг? Гүйцэтгэдэг? Хариуцдаг? Хэрхэн хамтардаг?

Хууль зүйн тогтолцоо
ХЗДХЯ
Дээд шүүх, шүүгчид

НХ тогтолцоо
НХХЯ

Бусад
ХТҮГ
ХТҮЗ
ХЭҮК
БСШУЯ
Засаг дарга

Хөгжлийн төлөө мэдээлэл, харилцаа²⁷

Зөвлөмж: Хөгжлийн төлөө мэдээлэл харилцаа нь Хүүхдийн хууль, эрх зүй хөтөлбөрийн нэг гол хэсэг нь байх ёстой. Ингэснээр, хүүхэд хамгааллыг дэмжих хүүхэд, эцэг эх, орон нутгийн иргэдийн дуу хоолойг сонсох боломжтой болно. Хөгжлийн төлөө мэдээлэл харилцаа нь гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, гэрч, хохирогч хүүхдийн асуудлаар нийгмийн өөрчлөлтийг санаачлах, идэвхжүүлэх, зан үйл өөрчлөх зэргээр хөтөлбөрийн үр дүнг дэмжиж, бодлогын шинэчлэлтэнд нөлөөлөх юм. Улс орны дараагийн хөтөлбөрийн төлөвлөлтийг хийхдээ Мэдээлэл, харилцааны хөтөлбөртэй хамтран ажиллаж Хүүхдийн хууль, эрх зүйн Хөгжлийн төлөө мэдээллийн стратегийг боловсруулах хэрэгтэй. Ингэснээр хүүхдийн төлөө хууль зүйг нийгмийн хэм хэмжээ болгох байр суурь, хандлагыг олон нийтийн оролцоотойгоор дэмжих; бэрхшээлтэй асуудал болон гарах арга замыг олоход гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, гэр ба хохирогч хүүхэд, тэдний гэр бүлтэй хамтран ажиллах; зан үйл, нийгмийн өөрчлөлтийг хянах боломжтой юм.

3.7 Хүүхдийн хууль, эрх зүй || 2012-2016 ||

Зөвлөмж: Хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийг хамгаалсан, тэднийг гэмт хэрэг, эрсдлээс урьдчилан сэргийлсэн орчныг бий болгох хууль зүйн тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй. Энэ нь хууль зүй, нийгмийн хамгааллын тогтолцоо, хүүхдийн эрхийн байгууллагуудын хамтын ажиллагаа бэхжсэн байх явдал юм.

2012-2016 онд Хүүхдийн хууль зүй хөтөлбөр эрх зүйн шинэтгэл хийх, хүүхдийг хамгаалах, тэдэнд аюул учрахаас урьдчилан сэргийлэх байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, мөн бодлого, хөтөлбөр боловсруулах, нөлөөлөх ажлыг баримт, нотолгоонд суурилан хийхэд анхаарах хэрэгтэй.

²⁷ ХХЗТ нь хувь хүний зан байдал, нийгмийн нааштай өөрчлөлтийг авч ирэх системтэй, төлөвлөгөөтэй, баримтанд тулгуурласан стратегич ажиллагаа байх болно. Энэ нь хөгжлийн хөтөлбөр, бодлогын нөлөөлөл, хүмүүнлэгийн үйл ажиллагааны хэсэг байх болно. ХХЗТ нь хүүхэд, гэр бүл, олон нийтийн санал бодлыг сонсож байх болно. Орон нутгийн нөхцөл байдлыг чухалчлан үзэж, төрөл бүрийн арга барил, суваг, хандлагаар хандах болно. ХХЗТ нь олон нийтийн харилцаа биш юм. Дараахь сайтийг үзнэ үү. <http://origin-www.unicef.org/cbsc/index.html>